

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-20 22/112/-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Даланзадгад хот
2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс аудит” ХХК

Захирал: Ш.Ичинхорлоо
Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	23.8	34
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	375.7	420.8
	Нийт хөрөнгийн дүн	399.5	454.8
	Нийт өр төлбөрийн дүн	(1.0)	-0.4
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	398.5	454.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	399.5	454.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	566.1	653.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	604.2	588.7
	Үйл ажиллагааны үр дүн	(38.1)	65.1
	Үйл ажиллагааны бус үр дүн	(18.8)	-9.3
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(56.9)	55.8
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	237.1	237.1
	Тайлант оны үр дүн	161.5	217.3
	Эцсийн үлдэгдэл	398.6	454.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	565.5	558.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	560.0	555.8
	Үйл ажиллагааны ЦМГ	5.5	3.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(5.5)	-3.6
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-0.5
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.9	1
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1.0	0.4
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	545.8	545.6
	Урсгал зардал	545.8	545.6
	Хөрөнгийн зардал	-	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	545.8	545.6

Улсын төсвөөс санхүүжих	537.8	537.6
Орон нутгийн төсвөөс	-	0
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	8.0	8.0

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Эрүү, иргэн, захиргааны, зөрчлийн хэргийн талаарх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний хүрээнд мэргэжлийн манлайлал, технологийн дэвшил, цахим шилжилтэд тулгуурлан нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглүүлэн үр дүнтэй зохион байгуулах ” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадварыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бэхжүүлнэ;
- Хүний хөгжлийг дэмжсэн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэн, иргэд олон нийтийн оролцоог хангана ;
- Эрүү, иргэн захиргаа, зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг байгууллагын хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах;
- Төрөөс баримтлах бодлого, чиглэлтэй уялдуулан байгууллагын гүйцэтгэлийг сайжруулж, шударга ёсыг бэхжүүлэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тогтолцоог төлөвшүүлэх, санхүүгийн сахилга батыг чанд сахина.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллага дээд шатны байгууллагын баталсан “Дотоод хяналт, шалгалт явуулах журам”-ын дагуу дотооддоо хяналт шалгалтыг дараахь чиглэлээр зохион байгуулан ажилласан байна. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр;
- Хуяглан хүрэх ажиллагааны чиглэлээр;
- Цагдан хорих байрны чиглэлээр;
- Шигэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр;
- Санхүүгийн чиглэлээр.

Санхүүгийн чиглэлээр хийсэн хяналт нь санхүүгийн үйл ажиллагаа болон эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн болон өөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт гэсэн ажлуудыг хамарсан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Өмнөговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Эрүү, иргэн, захиргааны, зөрчлийн хэргийн талаарх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний хүрээнд мэргэжлийн манлайлал, технологийн дэвшил, цахим шилжилтэд тулгуурлан нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглүүлэн үр дүнтэй зохион байгуулах ” зорилгын хүрээнд 4 зорилтын 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл нь 94.1 хувийн хэрэгжилттэй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 54,855.0 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 49,884.9 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 1 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 3,970.1 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

7.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
						Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар															
1	Байгууллагын нэр	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой шинээр үнэлсэн үндсэн хөрөнгийг дахин үнэлгээний нэмэгдэл дансанд буруу бүртгэж тайлагнасан	Аудитын явцад залруулсан	1	26,096.6	1	26,096.6								